



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар A-202

Улаанбаатар хот

“Монголбанкнаас төлбөрийн системийн
талаар баримтлах бодлого”-ын баримт
бичиг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх
заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого”-ийн баримт
бичгийг хавсралтаар баталсугай.

2.Тус бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж ажиллахыг Төлбөр тооцоо,
бүртгэлийн газар (М.Амгалан), Мэдээллийн технологийн газар (Д.Довчинбазар), Хяналт
шалгалтын газар (Б.Лхагвасүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, үйл
ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14 1748

Tushaal 2012.doc

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012
оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
4 2012 дугаар тушаалын хавсралт

**МОНГОЛБАНКНААС ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН
ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО**

УХИ0014

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монголбанкнаас төлбөрийн системийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын төлбөрийн системийн зорилго, түүний бүтэц бүрэлдэхүүн, оролцогч талуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон баримт юм.

1.2. Энэхүү бодлого нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүгүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

2. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ЗОРИЛГО, БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН

2.1. Төлбөрийн систем нь төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагчийн хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, түүнийг гүйцэтгэх, үр дүнгийн тооцооллыг хийх эрх бүхий байгууллага (цаашид системийн оролцогч гэх), холбогдох дурэм, журам, гэрээ болон төлбөрийн хэрэгслийн цогц нэгдэл юм.

2.2. Төлбөрийн системийн үндсэн зорилго нь системийн оролцогч хооронд хийгдэх төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг хангахад оршино.

2.3. Монголбанкнаас төлбөрийн системийн үндсэн зорилтыг хангах үүднээс дараах бодлогыг баримталаа:

- 2.3.1. Бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг дэмжих, шинэ дэвшилтээ төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх, олон улсын жишигт хүрсэн төлбөрийн системийн дэд бүтцийг хөгжүүлэх;
- 2.3.2. Төлбөрийн системд үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, түүнийг үнэлэх, удирдах, зохистой хяналт, зохицуулалтыг авч хэрэгжүүлэх.

2.4. Төлбөрийн систем нь дараах төлбөр тооцооны системээс бүрдэнэ:

- 2.4.1. Их дүнтэй төлбөр тооцооны систем;
- 2.4.2. Бага дүнтэй төлбөр тооцооны систем;
- 2.4.3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой төлбөр тооцооны бусад систем.

2.5. Төлбөр тооцооны системд үүсч болзошгүй эрсдэл нь нийт эдийн засаг, санхүүгийн зах зээлийг хамарч, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж болох тул төлбөрийн систем нь санхүүгийн зах зээлийн нэн чухал дэд бүтэц юм.

2.6. Төлбөрийн систем нь дараах хэсгээс бүрдэнэ:

- 2.6.1. Төлбөрийн хэрэгсэл;
- 2.6.2. Системийн оролцогч ба оператор;
- 2.6.3. Холбогдох хууль, тогтоомж;
- 2.6.4. Техник технологи, програм хангамжийн шийдэл бүхий дэд бүтэц.

3. ТӨЛБӨРИЙН СИСТЕМД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

Монгол Улсын төлбөрийн системийн үйл ажиллагаанд дараах этгээд оролцоно:

- Төв банк (Монголбанк);
- Системийн оролцогч;
- Системийн оператор.

3.1. ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Монголбанк нь дараахы үүргийг хүлээнэ:

3.1.1. Төлбөрийн системийн үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.1.1. Монголбанк нь энэхүү бодлогын 2.4-т заасан төлбөр тооцооны системээр дамжуулан системийн оролцогч хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэнэ.

3.1.1.2. Төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг хангана.

3.1.1.3. Системийн оролцогчтой гэрээ байгуулж, тэдгээрийн харилцах дансыг өөр дээрээ байршуулна.

3.1.1.4. Системийн операторын үйлчилгээний шимтгэлийн хэмжээг тогтооно.

3.1.2. Төлбөрийн системийн үйл ажиллагааг зохицуулна.

3.1.2.1. Төлбөрийн системийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны дүрэм, журам, тавигдах шаардлага, зохистой үзүүлэлтийг тодорхойлно.

3.1.2.2. Төлбөрийн системийн үйл ажиллагааг ОУТТБ-наас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудад нийцүүлэн зохицуулна.

3.1.2.3. Системийн оролцогчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангуулах үйл ажиллагааг зохицуулна.

3.1.2.4. Системийн оролцогч, төлбөр тооцооны систем хоорондын харилцаан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангуулна.

3.1.3. Төлбөрийн системийн үйл ажиллагаанд оролцоно.

3.1.3.1. Монголбанк нь өөрийн болон Засгийн газрын нэрийн өмнөөс төлбөр тооцоо гүйцэтгэнээр төлбөрийн системийн оролцогч болно.

3.1.4. Төлбөрийн системд хяналт тавьж, хяналт шалгалт хийнэ.

3.1.4.1. Төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор төлбөрийн системд хяналт тавьж, үйл ажиллагаанд шалгалт хийнэ.

3.1.4.2. Монголбанкнаас гаргасан бодлого, журмын дагуу төлбөрийн системд хяналт тавьж, шалгалт хийнэ.

3.1.5. Төлбөрийн системийг хөгжүүлэхд үдирдан чиглүүлнэ.

3.1.5.1. Шинэ дэвшилтэд технологийг ашиглан төлбөрийн системийн үр ашгийг дээшлүүлж, төлбөрийн системийг хөгжүүлэх ажлыг үдирдан чиглүүлнэ.

3.1.5.2. Бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх, шинэ үйлчилгээг нэвтрүүлэх, нийтийн хэрэглээ болгоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.2. СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Системийн оролцогч нь Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг авч, төлбөрийн системийн үйл ажиллагаанд оролцож буй эрх бүхий байгууллага юм.

Системийн оролцогч нь дараах үүргийг хүлээнэ:

3.2.1. Холбогдох хууль, журам, дүрэм, бусад шаардлагад нийцүүлэн төлбөр тооцооны үйлчилгээг нийтэд найдвартай, шуурхай үзүүлнэ.

3.2.2. Монголбанкны зөвшөөрөлтэйгээр бэлэн бус төлбөрийн хэрэгсэл гаргана.

3.2.3. Төлбөр тооцооны систем хоорондын харилцан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангаж, системийн оператораас гаргасан үйл ажиллагааны дурмийг мөрдөнө.

3.3. СИСТЕМИЙН ОПЕРАТОРЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Системийн оператор нь Монголбанкны зөвшөөрөлтэйгээр системийн оролцогч хоорондын гүйлгээг дамжуулах, үр дүнгийн тооцоог хийх, төлбөрийн системтэй холбоотой бусад үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий байгууллага юм.

Системийн оператор дараах үүргийг хүлээнэ.

3.3.1. Бага дүнтэй төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангана.

3.3.2. Монголбанкны бодлого, журам, бусад шаардлагад нийцсэн, төлбөр тооцооны систем хоорондын харилцан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангасан үйл ажиллагааны дурэм, техникийн стандартыг тодорхойлно.

3.3.3. Төлбөрийн системтэй холбоотой бусад үйлчилгээг системийн оролцогчдод үзүүлэх, төлбөрийн хэрэгслийн үр ашгийг нэмэгдүүлж, нууцлал, аюулгүй байдлыг хангана.

4. ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1. Монголбанк нь найдвартай, үр ашигтай төлбөрийн системийг хөгжүүлэх, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор системийн оролцогч, системийн оператор, Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагатай хамтран ажиллана.

4.2. Төлбөрийн системийг олон улсад хүлээн зөвшөөрсөн стандарт, зарчимд нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор бусад орны болон олон улсын байгууллагатай хамтран ажиллана.

5. ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

5.1. Төлбөрийн системийн талаарх мэдээ, мэдээлэл, судалгаа, тайланг нийтэд мэдээлнэ.

5.2. Монгол Улсын төлбөрийн системийн тайланг олон улсын байгууллагад хүргүүлж, хэвлэн нийтлүүлж болно.

oOo